

**БОДОЛД УРГАСАН ЯРИЛЦЛАГА\*****ГАДААД ХЭВЛЭЛИЙН ХУУДАСНААС****Л. И. Гумилев, түүхийн ухааны доктор, профессор**

Маргаанд халтар хултар мэдлэгтэй эрдэм шинжилгээний ядмагхан ажилтан оролцож өгүүлэх нь:

Хэрэв сайн хүн, муу хүн гэж байдаг болбоос хаад ч өөрцгүй дөлгөөн найрамдуу буюу хэрцгий догшин гэж байж таарна. Чингис их байлдсаныг үзвэл харгис хаан байжээ.

**Зохиогч.** Суворов ч мөн л насан туршид байлдаж явсан хүн. Гэвч бид Суворовыг хүндэтгэж хүсэмжилдэггүйсэн бил үү?

**Эрдэм шинжилгээний ажилтан.** Би өөрийн үгээр биш, Г. Е. Гружм Гржимайло эрдэмтний үгээр ярьж байна. Чингэс хааны тухай түүний бичсэн нь «Хэрцгий дошгин, өш өвөрлөгч аймтгай амьтан, сайн эрийн төгс шинжийг омсгойдсон, хар амиа бодогч хулчгар нэгэн бөгөөд тэрвээр зөвхөн олз омгийн төлөөнөө л шийдвэрлэх цагт зоримог хөдөлдөг байлаа» гэжээ.

**Зохиогч.** Та ишлэл татахдаа их л шударга бус зан гаргалаадаа, Таслалын дараа тэнд бас юу гэж бичсэн байв гээч?! Би нөхөн гүйцээе: «Дээр өгүүлсэн нь ямар нэгэн хэмжээгээр үнэн болбоос Тэмүүжин нь Тэмүүжин биш байхсан. Өөрөөр хэлбэл тэр хүн идэр залуу насандаа нэг талаас нэг хэсэг хүмүүсийн үнэн сэтгэл, эвсэг найруу чанарыг өөртөө татаж, нөгөө талаас ард түмэнд нөлөөлөх өөрсдийнх нь хүч нөлөөг сулруулах буюу үгүй болгон үрэн таран хийх тийм сөрөг хүч нөлөө Тэмүүжинд байгааг анзаарч мэдэрсэн заримынх нь уур унтууцал, хор шарыг гозолзуулан, тэдний зүгээс ил дайсагнал, далд атаархлыг шатааж байлаа» -гэж Гружм-Гржимайло дурджээ. Их эрдэмтдийн үзэл бодлыг гуйвуулсан дорхноо, ишлэл зүүлт авахгүй л явбал сайнсандаа.

**...Дорнодахины түүхч.** Чингис, түүний хөвгүүд, ач нарынх нь хийсэн аян дайныг та хэр болгоохсон бол?

**Зохиогч.** Тэд хэнтэй байлдан тулалдаж байсныг анхааран авч үзэгтүн, Тэд Зүрчидийн булаан дээрэмдэгчид, угсаа гарал нэгтэй догшин өрсөлдөгчдөөсөө гадна Мэргэд, Хэрэйд, Найман, Хивчиг хэмээх половчууд, Хорезм шагийн гол хүчин болох пангли хэмээх печенгчүүд, туркмен-сельжук мөн харлаг зэрэг нүүдэлчидтэй л үзэлцэж байгаа шүү дээ. Дайн дажны хөлд өртсөн хүн ардад амар хялбар байгаагүй нь мэдээж боловч, уйгар, армян, никейн грекүүд шиг хань холбоотноо сонгож сурах хэрэгтэй юм. Монголчуудыг довтлон зовоосон Зүрчидээс Монголын булаан авсан хязгаар нутгийг салгаж нэгтгэх хэмээсэн Сун улсын өөрийнх нь мугуйд төрийн бодлого Хятад-Монголын удаан үргэлжилсэн дайны уг шалтгаан нь болсон билээ.

\*Өгүүллийн эхний хэсгийг «ДДСА» сэтгүүлийн 1988 оны № 2-оос үзэм уу. Жич: Сэтгүүлийн үг дугаарын 94 дахь талын доороос дээш гуравдахь өгүүлбрийг: 200 жилийн урьд польшууд Москваг үнсэн товрог болгож байхад оросуудын энэ эрхэм дээд газар шороог тэдний гараас Минин, Пожарский нар эгүүлэн булаасан шүү гэж залруулан үншина уу.

**Дорно дахины түүхч.** Та чинь Монголын байлдан дагуулал, цус урсгалтыг зөвтгөх гээд л байгаа хүн үү дээ?!...

**Зохиогч.** Үгүй ээ! Би зөвхөн өөрөөсөө илүү хүчтэй дайснаа Монголчууд хэрхэн ялж байсны учрыг л олох хэмээсэн билээ. Хэн нь сайн, хэн нь муу гэх яриа бол утга учиргүй яриа юм. Монголчууд цуст яргалал үйлдсэн гэж та ярьж байна. Тэгвэл 1099 онд загалмайтнууд Иерусалим хотноо зоргоор загнаж өлгийтэй хүүхдийг ч өршөөлгүй улаан ярга үйлдсэнийг юу гэхсэн бол?! Тэд бас 1204 онд Константинополийг хэрхэн талж дээрэмдлээ?!... Мөн 1370 онд Лиможийн бүх оршин суугчдыг хүйс тэмтрүүлэхээр Хар хунтайзыг буулгасан зарлигийг юу хэмээн үзвээс зохилтой вэ? Хар хунтайзыг англичууд үндэсний баатраа гэж эрхэмлэн хүндэтгэцгээж байна! Чухамдаа түүний бие юугаараа монголчуудаас «илүү» ариун болчихоо билээ?! Гэвч хэргийн учир үүнд байгаа юм бишээ! Хэргийн учир хүчгүй нь хүчтэйгээ ялж, яллаж байсны шалтгааныг тогтооход байгаа юм. Нийгмийн ухааны арга зүйг баримталсан түүх маань энэ асуултанд хариулт оноож чадахгүйнэ! Тэгэхлээр арга зүйгээ солих хэрэгтэй болжээ. Байгалийн ухаанд л хандах зам үлдэв. Угсаатны алив системийг хөдөлгөөнд орших биетэй жишиж адилтгаж болох бөгөөд биеийн хөдөлгөөний төрх байдлыг гурван зүйл хэмжигдэхүүнээр, тухайлбал, цул нягт (хүн амын олон цөөн), эрч (хүчний хуримтлал), бүрэлдэхүүн (системийн доторхи бүрдэл хэсгүүдийн амьд зохицол)-ээр тодорхойлдог билээ өсөлт өрнөлтийнхээ шатанд яваа угсаатнууд төлөв сүүлчийн хоёр шинжийг өөртөө агуулсан байдаг юм. Энэ утгын үүднээс авч үзвэл XIII зууны монголчууд нь винингчүүд, түрүү цагийн Халифын арабчууд, Чанийн зулусууд, II зууны готуудын ижил байдалд оршиж байлаа. Өсөлт өрнөлтийн шат ард үлдэхэд угсаатны оршин тогтнох систем эхлээд хэт дэврэлтээс болж дотоод зөрчилдөө идэгдэн сулардаг бөгөөд ягуухнаар бууралтын шат өртөөлөн залгаж, өмнө үеийхээ нэгдмэл цул шинжийг умартахад хүрдэг байна. Монголчууд гэвэл өсөлт өрнөлтийнхөө үед харьцангуй идэр залуу угсаатан байсанд л тэдний амжилтын нууц оршиж байгаа юм. Энэ дүн шинжилгээ эдүгээ мэдэгдэж буй бүх баримт хэрэглэгдэхүүнд ер харшлахгүй байгаа бөгөөд 1260 онд Монгол төр улс бутарч унасны шалтгааныг ч нэгэн зэрэг тайлбарлах болно.

**Оросын түүх судлаач.** Та энэ үзэл бодлынхоо үүднээс хэн бүхний мэдэх «татарын талхи-хэмээх нэр томъёог яаж тайлбарлахсан болоо? Жирийн орос хүмүүс Алтан Ордны улсын ноёрхолд хүндээр тарчилж, Алтан Ордыг «талхи» гэж нэрлэсэн нь талаар хэрэг биш баймаарсан!...

**Зохиогч.** Бүхий л улс орны жирийн хүмүүс засгийн газартаа татвар түрээс төлөхдөө баярлаж цэнгэдэггүй юм. Нөгөөтэйгүүр газар сайгүй хаана ч байдаг ийм явдлыг тэр болгон «талхи» дарлал гэж нэрлэдэггүй билээ. Францад бретонууд, гаскончууд, провансальчууд Парижид ширээгээ зассан францын ванд түрээс татвар төлж л байв. Тэдний аль аль нь франц угсаатнууд биш гэдгийг өгүүлэлтэй, Францчууд тэднийг зөвхөн XIII-XV зуунд л тун харгис хэрцгийгээр байлдан дагуулсан билээ. Энэ хүртэл тэд, нэг бол Англитай (Бретан, Гасконь), үгүй бол Германтай (Лангедок) хоршиж холбогдож байсан юм. Та О. Тьеррийн бүтээлүүдийг унш л даа.

**Оросын түүх судлаач.** Гэтэл Бат Оросыг байлдан эзэлж, алба татвар тулгаж байсныг хэн хэнгүй л мэднэ шүү дээ!

**Зохиогч.** Бат үнэхээр 1237—1238 онд 3 түмэн морин цэргийг толгойлон Рязан, Владимир, Черниговын вант улсуудын нутгаар дайрч өнгөрсөн юм. Бат хаан хот суурин газар цэргийн анги хороо үлдээгээгүй бөгөөд тэгэхлээр алба татвар тулгаж байсан гэх нь учир утгагүй үг болж байна. Харин 20 жилийн дараа Александр Невский Берке хантай дипломат хэлэлцээ явуулсны үр дүнд Оросууд Алтан Ордонд алба татвар төлөх болсон юм. Оросод тэр үед германчууд занал учруулж байсан бөгөөд Александр Невскийд холбоотон ямархуу амин чухал хэрэгтэй, яахан үгүйлэгдэж байсныг нурших нь илүүц хэрэг. Орос ба монголчуудын Алтан Ордны улсын холбоо германчуудын дорно зүг аялах довтолгооныг сатааруулан зогсоожээ

**Түүхч.** Гэхдээ л орос хүмүүс татарын талхинд хэлмэгдэн тарчилж байлаа!

**Зохиогч.** Эртний орос хэлэнд «Иго» (талхи) гэдэг олон салаа утгатай. Хазаар хомны бэхэлгээг «талхи» гэж хэлдэг байв. Мөн «ачаа», «дарамт», «үүргэвч» гэсэн ч санаа бий. «Иго» нь «талхи», «дарлал», «ноёрхол» гэсэн утгаар гэвэл Петр 1-ийн үед 1691 онд анх түрүү «Москвагийн вант улсын талхинд ихээр зовж байна... гэж запорж нутгийнхан бичжээ» гэсэн тэмдэглэлд туссан байгаа юм.

**Түүхч.** Тэгвэл XIV—XV зууны оросууд маань Алтан ордны ноёрхолыг чухам юу гэж оноож нэрлэж байсан байх нь вэ?

**Зохиогч.** Тэд маань Алтан ордны хааныг «царь» (хаан) л гэж нэрлэж байв. Он дарааллын сударт «сайн хаан Джанибек тэнгэрт халичихжээ» гэж тэмдэглэснийг аваад үз л дээ. Сарайд дээдцүүлийн хооронд алаан хядаан болж, эв эс бүрнээ алдагдаж байсан 1357—1380 оны «Их самуун»-ы ид үед ч Оросын вангууд Алтан ордон руу «выход» буюу алба татварыг хүргүүлсээр ирсэн байх юм. Алтан Ордонд алба татвар өгч байгаагүй муж, орон нутаг польшуудын талхинд орж шүү дээ.

**Түүхч.** Тэгэхлээр яагаад хэн ч «Польшийн талхи» гэж ярьдаггүй, харин «татаарын талхи» гэж байсныг хэн хэнгүй мэддэг болж таарч байна?

**Зохиогч.** «Татарын талхи» гэдэг үгийг хэрэглэх болсны учрыг 1980 онд хэвлэгдсэн В. В. Каргаловын «Алтан Ордоны талхи зарлалын мөхөл» хэмээх номонд тайлбарласан байна. Ван Стефан Баторийн төрийн нарийн бичгийн дарга Рейнгольд Гейденштейн «Москвагийн дайны тухай тэмдэглэл» хэмээх номондоо анх энэ үгийг авч хэрэглэжээ гэж В. В. Каргалов цохож тэмдэглэсэн байна. Тэрвээр III Иваны үйл ажиллагааны тухайд хэд хэдэн чухал үнэлэлт дүгнэлт хийжээ. Оросын он дарааллын судрыг туурвигч (Казаны он дарааллын судар) өгүүлэхдээ: III Иван «тариачны шашин (христос)-ыг сүсэглэн дээдэлж, Ордоны хаан Ахмадад өш өвөрлөөд хамаг аюул нүүрлэн дайрахыг үл эрхшээн хааны эсрэг эр зориг, эрдэнэт илдээ хурцлан босож, зардас элч нарын салхи адил дураар зорчихыг зоргоор зогсоож, алба татвар Ордон тийш зөөхийг цугаар болиулж, өөрийн биеэр Алтан Ордонд морилохоо эгнэгт огоорсон тэнгэр их зоригийг үзүүлвэй» гэжээ.

Уград болсон дайныг тухайн үед бослого гэж хэн ч үзээгүй нь энэхүү ишлэлээс тод байна. Харин шударга биш хаантны эсрэг, христос шашны төлөөнөө хийсэн дайнд л илүү учир холбогдол өгсөн нь эндээс тодорхой. Богдан Хмельницкий нэгэн цагт Москвагийн хаан Алексей-ийн эрхшээлд явахдаа уул эрхшээлийг талхи» гэж бодоогүйтэй нэгэн адил III Иван Алтан Ордоны «талхи» дарлалд өөрийгөө байна гэж сэтгээ ч үгүй ажээ гэх бодол эндээс төрөөд байгаа юм. XVII—XVIII зуунд Украиныг Оросод нэгтгэхийг сөрж тулсан хүч байсан хэдий боловч ард түмэн тэр хүчийг дэмжсэнгүй. Учир нь Москвагай холбоотон болохоос татгалзах нь Польшид ч юмуу Туркэд эсвэл Швейдэд захирагдах гэсэнтэй үлгэр нэгэн байж билээ. II Иван хаан гэвэл татаруудыг алба ажилдаа зүтгүүлж байсан хүн. Тухайлбал Крымын татаар Нур-Даулет Москвагийн цэргийг манлайлан Ижил мөрнийг уруудан бууж, Сарайд цохилт өгөөд Ахмет хааныг ар талаас нь ангижруулсан нэг явдал бий. Үүгээр Ахмет найдваргүй мөхлийн замдаа орсон юм шүү дээ.

Хэрэв Алтан Ордон Зүүн Европ, Баруун Сибирьт эрх засгаа тогтоосныг «талхи» гэж үзэх аваас Киев, Волынь, Белорусс зэрэг Оросын уугуул ус нутаг дахь Латвинхны эрхшээлийг юу гэж нэрлэх болж байна? Каргаловын анхааран тэмдэглэсэн нь: «Гейденштейний зохиомол сэдвийг францын нэрд гарсан түүхч де Ту өлгөн авч тарааснаар уул сэдэв сүүл сүүлдээ түүхийн утга зохиолд ихээхэн газар авсан юм» гэжээ.

**Газар усны эртний нэрийн судлаач.** Би таньтай санал зөрж байна. Та «Алтан Ордоны улс нь дорнын довтлох аюулаас Оросыг халхавчилан хамгаалж, чухам үүний үр дүнд Орос нь батжин хүчирхэгжсэн» гэж бичжээ. Ингэж батлах гэх нь түүхч-газар зүйн ойлголтын илэрхий төөрөгдлөөс шалтгаалсан бололтой. Учир нь Дорноос хэн ч Оросыг довтлох гэж заналхийгээгүй билээ. Тэр үед бүр далайн эргийг хүртэлх бүх газар нутаг монголчуудын эрх засаг дор оршиж байлаа шүү дээ. Бас, Та яагаад намайг газар усны нэрийн судлаач гэв? Би чинь түүхч-газар зүйч хүн шүү дээ.

**Зохиогч.** Би яагаад Таныг газар усны нэр судлаач гэв ээ гэвэл, түүхч-газар зүйч нар үгийн утгыг голчилон анхаарч ирсэн байхад Та үгийн дуудлага, аялгууг л шохоорхоод байгаагийн учир тэр юм. Миний дээр хэлсэнчилэн монголчууд бие даасан таван төр улс байгуулсан хүмүүс ээ. Нэрлэвэл, Хятадад Юань гүрэн, Иранд илхаадын улс, Дунд Азид Цагаагадын улс. Ижил мөрөн, Казахстанд Зүчийн улс, Зүүнгарт өгөөдэйн үр сад нарын өвөрмөц нэгэн улс-ийм таван улс болно. 1259 оноос 1307 оны зурвас үед эд улс өөр хоорондоо цус урсгасан дайн явуулж байлаа. Монгол-хятад ба монгол-ираны хоёр улс талынхан болох Алтан Ордоны ба хан Хайду, түүний хүү Чапарын харъяаллын доорхи Зүүн гарын улсын эсрэг дайтацгааж байсан юм. Хувилай Хятадыг эзэлснээр хаанаас «тэнгэрийн хөвгүүнд» хувилж, яг хэлбэл их эзэн хаан болж билээ. Төрөлх Монгол нь засгийн эрхийг хууль бусаар булаан авагчийн хэмжээнд Хувилайг буруутган түүнтэй харгалзан тулж эхэлсэн амуй. Тал нутгийнхан баатарлан тулалдаагүйсэн бол Хувилай хятад цэргээ авч оросод хүрч ирэх байсан юм. Хятад цэргүүд гэвэл эзэлсэн нутаг орныхоо хүн ардыг хүйс тэмтрэн хомгорлож, өлгийтэй хүүхдийг ч өвгөн буурлыг ч өршөөдөггүй байсан

агаад ингэж яргалахаа жирийн л үйл явдал гэж үздэг байсан шүү, Талын улсууд тэсч чадсаны авралаар Юань гүрний цэрэг өмнө зүг эргэж, Хөх мөрний Чинад дахь уулын ширэнгийг зорьжээ.

**Газар усны эртний нэрийн судлаач.** Тэгэхлээр монголчууд эвдэлж сүйтгэсэн боловч буруутан биш юм биз дээ? Тэд чинь соёлт хотуудыг нурааж, хүмүүсийг алж хядаж байлаа.

**Зохиогч.** Тэдний дайснууд эвдэлж нураадаггүй, алж хяддаггүй байсан гэх нь үү! Манжийн хаан Цянь Лун 1757 онд хятад цэргийг толгойлон орж, Зүүн гарын монголчуудыг хүйс тэмтрэн, хоморголон хядсан шүү дээ. Нэгдсэн хятад үеийн үед л тэлж өргөжсөөр ирлээ. Ийм байдал Хятадын хилийг өрнө тийш тэлсэн Монголын Юан гүрэн, манж Чин гүрний үед ч нэгэн адил ажиглагдаж байлаа. Аз болоход монголчууд, Ойрд нар баруун хойт зүг хятадуудын хийх болзолт довтолгооныг XVIII зууныг хүртэл торголзуулан саатуулж билээ. Энэ завсар Орос орон бэхжлийг олж амжсан төдийгүй, улсын хатуу хил тогтоож чаджээ. Хэрэв манж-хятадууд нь оросууд хариу эсэргүүцэл үзүүлж чадахгүй байсан XII зуунд баруун хойт зүг хөтөлсөн бол юу болох байв аа? Киевийн орос жижиг вант улсууд болон сарнин бутарсан тэр цагт манж-хятадууд Ижил мөрөн, Днеприйг дорхноо хүрчих байлаа.

Гэтэл Батын толгойлсон цөөн тооны монгол цэрэг оросыг дамжиж өнгөрөөд л, тал нутагтаа буцчихсан хэрэг шүү дээ. Харин хятадууд бол тун олон олноороо орж ирэх байсан бөгөөд эзэлсэн хотууддаа амарханаа суурьшиж авчихаад буцаж гарахгүй л байсан болов уу. Хэрэв Монгол-гүрэг угсаатны зөөлөвч байгаагүй бол ийм л явдал болох байсан юм. Тэр зөөлөвч тоогоор цөөн ч, дайнч хүчирхэг чадвараараа гаргуун байжээ...

### ДҮГНЭЛТ

XIII зуунд Монголын төр улс хэрхэн байгуулагдсан вэ гэдэг асуудлаар түүхэн өөр аль ч үзэгдлийн талаар гараагүй завхаж мушгисан олон үзэл бодол буй болжээ. Ийм завхруулгын үндэс нь XIV зуунд зохиогдсон Монголын эсрэг хуурамч шашдираар тавигдсан байна. Дараа нь итгэмтгий түүхч нар үйл явдлыг зурагласан Шашдирын үг үсгийн араас зууралдацгаасан ажээ. Бид өмнө нь нэгэнт хэлсэн болохлоор түүх шүүмжлэлийн асуудлыг энд гүнзгийрүүлэхээ зогсож, гагцхүү хэдэн тоо дурдъяа, XIII зууны эхэн үед Монголын хүн ам дайсагнагч аймаг ханлигуудад хуваагдсан далан түм орчимд л эргэлдэж байв. Хүн амын тооллыг хүн амын 20 хувийг эзэлж байсан цэрэг, өөрөөр хэлбэл эрчүүдээр барагцаалан явуулж иржээ. Далан Балжид Чингэс, Жамуха хоёрын хийсэн тулалдаанд хоёр талаасаа дөрвөн түм, гурван мянга орчим цэрэг оролцсон. Тэгэхлээр тухайн үед ердөө л хоёр зуун мянган монголчууд амьдарч байсан аж. Үлдэх байгаа хагас сая нь 1201—1210 онд Хамаг Монголын эрхшээлд орсон Хэрэйд, Найман, Мэргэд, Татаар нар болж байгаа юм. Монголыг эргэн тойронд нь бүсэлсэн бусад улс гүрнүүд гэвэл хүн амын хувьд хаа хамаагүй олон байжээ. Тангадын хаан төр гэхэд л 2 сая таван буман хүн амтай, тэдний таван бум нь цэрэг эрс байв. Зүрчидэд за-

хирагдсан хойт хятад, өмнөт хятадтайгаа нийлээд 80 сая, хорезм шагийнхан 20 сая, Дорнод Европ ойролцоогоор 8 сая-ийм л зураг харагдаж байна. Хүчний харьцаа ийм байхад монголчууд ялж дийлээд байсан нь эсэргүүцэл тун агдангүй байсных буйзаа. Үүнд бүс нутаг болгонд өвөрмөц байдал угсаа гарлын түүхэн явц нөлөө холбогдлоо өгчээ гэдгийг хамтад тэмдэглэлтэй. Гэвч угсаатнууд өөр хоорондоо харилцан үйлчилгээтэй явж ирсэн бөгөөд үүнээс их төлөв янз янзын, гэхдээ эмгэнэлт үр дагавар урхагшиж үлддэгийг ажиглахад төвөггүй. XIII зуунд гэвэл хэтэрхий ойр хаяа хатгаж нутагшсан ард түмнүүд их хэмжээгээр хэлмэгдэн зүдэрсэн бөгөөд харин үүнд буруутныг эрж, олж тогтоох гэх нь шинжлэх ухаанд харш явдал болохсон билээ. Хужирыг нимбэгний хүчилтэй хольж усанд найруулахад хөөсөрч дулаан ялгаруулна. Энэ бол байгаль дахь бодисын жамаар явагдаж буй саармагжилт урвал юм. III—V зуунд гот, вандал нар, IX-XI зууны винингчүүд, XII зууны загалмайтнуудын урсгасан цус тийм бага гэж үү? Үгүй ээ, багагүй! Гэтэл тэдний байлдан дагуулалт нь Римийн Бүгд найрамдах улсын газар нутаг өргөтгөгдөн тэлсэнтэй л ижил утгатай юм шүү дээ.

Арабууд VII—VIII зуунд перс, армян, испани, вестгот, берберчүүдийн дунд аллага хядлага явуулж, согд нарыг хүйс тэмтэрсэн бөгөөд согдын гал голомтыг хадгалж хоцорсон хэдхэн тооны реликчүүд эдүгээ Гиссор, баруун Памирын үл нэвтрэх бөглүү хавцалд аж төрж байна. Энэ бүхний дэвсгэр дээр авч үзэхэд зөрчид, Монголчуудын угсаа гарлын хөгжлийн дэлбэрэлт нь тийм ч харш онцгой үзэгдэл биш гэдэг нь, нэгэн зэрэг тухайн үеийн түүхч, он дарааллын бичиг зохиогчид XIII зууны үеийн явдлыг үзүүлэхдээ хар будаг хайрлаагүй нь ажиглагдаж байна.

Угсаа гарал бол байгалийн үзэгдэл шалгарлын үр хөврөл юм. Хэн бүхний мэдэж байгаагаар байгаль ээж маань сайн, муу алийг ч тунгаан ялгадаггүй билээ. Шороон шуурга, цасан нураг, газар хөдлөлт хүмүүн амьтанд зовлон авчирдаг нь мэдээж. Гэвч тэр бүхэн дэлхий гаригийн газарзүйн бүрхүүлийн бие бүрэлдэхүүнд л багтдаг. Дэлхийн бүрхүүлд шороон мандал, усан мандал, агаар мандлаас гадна шим мандал ордог бөгөөд шим мандлын цогц хэсгийн ихээхэн нь түүхий тодорхой хэрчим хугацаанд үүсэн буй болж, устан алга болдог угсаатнаас бүрэлдэгч хүн мандал юм. Байгалийн үзэгдэл, нэгэн зэрэг угсаатны хөгжлийг зан суртахууны үнэлэлтээр тодорхойлж болохгүй. Яагаад гэвэл тэдний аль аль нь популяцын төвшинд явагддаг бөгөөд харин ёс суртахууны хариуцлагыг хэрхэн тодорхойлох нь махбодь буюу хувь хүний төвшиндөх, хувь хүний асуудал юм. Угсаа гарал нь хөгжлийнхөө аль ч шатанд байгалийн шинжлэлийн судлагдахуун болох ёстой нь үнэн авч, байгалийн ухааны аргаар боловсруулбал зохих хэрэглэгдэхүүнийг өөртөө агуулагч түүхийг танин мэдэх замаар л угсаа гарлыг судалж болох билээ.

Түрэг-Монголын талаархи үзэл баримтлалыг роман-германыхтай жишиж дүйлгэж үзвээс, үзэл баримтлалуудын ижил төстэйг хийгээд ихээхэн ялгаатайг бид өөрийн эрхгүй ажиглахсан билээ. Тодруулбал аль аль нь сэтгэлийн хөөрөл хөдөлгөөнд буюу чухам хэлбэл шинжлэх ухааны өчүүхэн ч үнэргүй, түүхийн үүднээс шүүмжлэлгүйгээр өнгөрсөн үеийн явдлыг буулгасан уламжлалт хандлагад тулгуурласныг

олж тогтоох ёстой. Чингэсийн байлдан дагуулалт нь түрэг-монголчуудын тухайд гавъяа, европынхны хувьд тэднийг азаар тойрсон гай юм.

Түрэг, монголчуудад үзэл бодлоо хамгаалж нотлохын хэрэгцээ үгүй ажээ. Учир нь тэдний үзэл бодол бол ухаан үл хүрэх онол биш, зүгээр л хүртэмж, мэдрэмж юм. Их овгийнхоо онгоныг сүслэн хүндэтгэхдээ тэд алтан нарыг алган дээрээ үзэж, зэсэн улаан галын элчийг мэдэрч, цэцгийн анхилуун үнэрт согтоорхох мэт болдог байна. Энэ бол баримт хэрэглэгдэхүүн үл шаардах энгийн үнэн юм. Харин франц, германчуудын монголчуудыг үзэн ядах хорсол огт хоосноос урган гарсан учир тэд түүндээ иш үндэс эрж сурагладаг байжээ. Энэ учираар европынхны онол гэгч гарсан юм. Тодруулбал хоттой хонинд орсон чоно мэт өөрсдийнхөө хядсан «соёлгүй», «хашин хойрго», ази, африкийнхан, индиан полинезчуудад бүслүүлсэн соёл иргэншлийн төв нь их Европ юм гэж тэр онол «нотолдог» бөгөөд «соёлгүйчүүд»-эд Оросыг ч адил хэмжээнд хавсаргажээ.

Европ төвийн тогтолцоот үзэл баримтлалыг оросууд ямар ч нягтлал, шүүмжлэлгүйгээр хүлээж авсан юм. XVI-XVII зууны Оросын Ихс думын түшмэл нар хавчин гадуурхах атгаг санаа өвөрлөөгүйн учир татаар, башкир, халимагийн морьт цэргийг Польш, Шведийн эсрэг зоримог ашигладаг байсан атал XIX зууны гэгээрсэн язгууртнуудын амны уншлага болсон «татаар» гэдэг үгнээс «зэрлэг, догшин», «дураар авирлагчид» гэх утга салахаа больсон билээ. Энд өгүүлэгдэн бүхий асуудалд түүхийн үүднээс шудрагаар хандвал зохилтой гэж үзэж байна.

Орчуулсан **Д. МААМ**

### **ЛЮ ШАОЦИ-ГИЙН «ОНЦГОЙ ХЭРЭГ»**

**Ю. М. Галенович**

Хятадын Коммунист нам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын удирдагчдын нэг, нэрт хувьсгалч Лю Шаоци 1988 оны 11-р сарын 24 нд нас сүүдэр 90 хүрэх байлаа. Хятадын хувьсгалын үйл хэргийн ялалтын төлөв зэвсэгт тэмцэл, нууц ажиллагааны хүнд бэрх жилүүдэд залуучуудын, дараагаар нь үйлдвэрчний эвлэлийн удирдагч байсан Лю Шаоци ХКН-ын удирдлагад голлох байр сууринд дэвшин гарч ирсэн юм. Хятадад ардын хувьсгал ялахад хийгээд БНХАУ байгуулагдаж, түүний социалист үндэс суурь үүсэн тогтох, олон улсын тавцанд Хятадын нэр хүнд өсөн бэхжихэд түүний байгуулсан асар их гавъяаг нийтээр хүлээн зөвшөөрдөг билээ.

Лю Шаоци 1927 онд ХКН-д элссэнээс хойш, намын удирдах дээд байгууллагад тасралтгүй ажилласаар иржээ. Тэрээр 1956 онд ХКН